



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/396

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, 16 зүйлийн 16.2, 16.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2018 оны 11 дүгээр сарын 01-ний эдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Монос Хэнтий" эм ханган нийлүүлэх төв, "Эмийн увидас-2", "Бумбат" эмийн сангуудын эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус 3 жилээр сунгасугай.

2. "Монос Хэнтий" эм ханган нийлүүлэх төвийн байршлыг Хэрлэн сумын 3 дугаар баг, Чингис цамхгийн үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт бүхий нэгдүгээр давхрын хэсэг болгож өөрчилсүгэй.

3. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаа/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА